Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 264.0 мянган төгрөг, хандиваар 6,970.4 мянга, АИТХТ-ийн 2020.05.21-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор газар 18,000.0 мянга, АИТХТ-ийн 2020.04.15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлсэн 19,623.3 мянга, нийт 44,857.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

АИТХТ-ийн 2020.04.15-ны өдрийн 23 дугаар тогтоолоор 898.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, АИТХТ-ийн 2020.04.15-ны 24 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 39,284.2 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, нийт 40,182.2 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 20,089.0 мянган төгрөг болж 16,889.0 мянган төгрөгөөр өссөн нь газар үнэ төлбөргүйгээр бүртгэж авсантай холбоотой байна

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр архив албан хэрэг хөтлөлтийн программ 264.0 мянга, АИТХТ-ийн 2020.05.21-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор газар 18,000.0 мянга, АИТХТ-ийн 2020.04.15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Хүүхдийн эрсдэлийн түвшин тогтоох программ 1,125.0 мянга, санхүүгийн программыг 250.0 мянган төгрөгөөр тус тус үнэлж, нийт 19,639.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, АИТХТ-ийн 2020.04.15-ны өдрийн 24 дүгээр тогтоол элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Хүүхдийн эрсдэлийн түвшин тогтоох программ 2,250.0 мянга, санхүүгийн программ 500.0 мянга, нийт 2,750.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Тайланд онд өр, төлбөрийн үлдэгдэлгүй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 99,853.4 мянган төгрөг болж 42,697.2 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн 19,623.3 мянга, тайлант оны үр дүн 5,073.9 мянга, үнэ төлбөргүй авсан газар 18,000.0 мянган төгрөг тус тус байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 21,707.4 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь Засгийн газрын тогтоолын дагуу 2020 оноос төрийн үйлчилгээний ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгодог болсноос шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс санхүүжилтийн орлого 197,361.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 18,662.3 мянга, үнэ төлбөргүй хөрөнгийн орлого 13,242.9 мянга, сахилгын суутгалын арга хэмжээний орлого 337.7 мянга, ахмадын сангийн орлого 1,150.8 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 13,848.4 мянга, нийт 244,603.8 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн байна.

Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвөөс санхүүжилтийн орлого 197,361.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 18,662.3 мянга, ахмадын сангийн орлого 1,150.8 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 13,848.4 мянга, нийт 231,023.2 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн байна

Нийт зардал өмнөх оноос 33,170.7 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин болон НДШ-ийн зардлууд нь төрийн үйлчилгээний ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгодог болсноос шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 292,424.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 292,424.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 81,214.8 мянган төгрөгөөр бууруулж 211,210.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь дээд газраас төсвийг төлөвлөснөөр баталдаггүйтэй холбоотой байна.

Харин өмнөх оны төсвөөс цалин НДШ-ийн зардлыг 8,864.1 мянга, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 4,305.1 хангамж бараа материалын зардлыг 3,735.9 мянга, дотоод албан томилолтын зардлыг 979.4 мянга, бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 1,200.2 мянга нийт 19,084.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 300.0 мянган төгрөгөөр хасаж баталсан байна.

Энэ нь тайлант онд үйлчилгээний ажилтан нарт удаан жилийн нэмэгдэл олгосон, Хүүхэд хамгаалах байрны тогтмол зардлыг хариуцдаг болсонтой холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72207-хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 1 арга хэмжээг 80101-үндсэн үйл ажиллагааны зардалд санхүүжүүлэхээр 211,210.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 197,361.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 13,848.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийн орлого 197,361.7 мянга, ахмадын сангийн орлого 1,150.8 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 13,848.4 мянга, нийт 212,360.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 210,864.2 мянган төгрөгийг зарцуулж, 27.3 мянган төгрөгийг улсын төсөвт, 909.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, ахмадын сангийн 560.0 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 210,273.3 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 909.4 мянга, хангамжийн бараа материалын зардлыг 0.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 2.9 мянга, хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардлыг 24.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ГБХЗГ-аас санхүүжилт 16,533.3 мянга, Хүүхдийг ивээх сангаас 1,320.0 мянга, ШШГГ-ын харъяа-425 дугаар нээлттэй хорих ангиас 659.0 мянга, Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ-аас 150.0 мянга, нийт 18,662.3 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин, НДШ-ийн зардалд 6,490.4 мянга, байр ашиглахтай холбогдсон тогтмол зардалд 1,678.5 мянга, хангамж бараа материалын зардалд 5,508.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,237.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 720.0 мянга, нийт 18,634.6 мянган төгрөгийг зарцуулж, 27.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Шилэн дансны мэдээллийг мөнгөн гүйлгээ болон анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулахад Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулсан тушаалыг мэдээлэхдээ 16 тушаалыг хугацаа хоцроож, 3 тушаалыг мэдээлээгүй, цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 45,912.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 2,985.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 42,926.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,985.3	1	2,985.3			
Зөвлөмж	3	42,926.9	3	42,926.9			
Нийт дүн	4	45,912.2	4	45,912.2			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 48,510.0 мянган төгрөгийн 13 алдаа зөрчил илэрснээс, 47,681.9 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, 828.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах 9 алдааны залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулсан бөгөөд үүний 21,008.2 мянган төгрөгийн 5 алдааг завсрын аудитаар илрүүлж, зөвлөмж өгч залруулсан ба бусад алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тусгай шилжүүлгийн 13,843.1 мянган төгрөгийн санхүүжилтийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэсэн
2. Санхүүгийн тайланд НДШ-ийн болон ХХОАТ-ын нийт 1,863.4 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн барагдуулж ажиллах
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын төлөвлөгөөг 4,540.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
4. Төсвийн гүйцэтгэлийн тайланд ахмадын сангийн зарлагыг 200.9 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн
5. Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл 560.0 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдлээр тайлагнасан
6. Бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй авсан бараа материал 5,382.4 мянган төгрөгийг ангилал зөрүүтэй болон дутуу тайлагнасан
7. Санхүүгийн үр дүнгийн тайланд шууд зардлыг 300.0 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй бүртгэсэн
8. Санхүүгийн үр дүнгийн тайланд дахин үнэлсэн 19,623.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлант үеийн орлогоор бүртгэсэн
9. Биетээр байхгүй бараа материал 1,368.0 мянган төгрөгийг дансны үлдэгдлээр тайлагнасан, авлага үүсгээгүй

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 828.1 мянган төгрөгийн залруулагдаагүй 2 алдаа, зөрчил илэрснээс 828.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроосон, хөрөнгө зарцуулсан тушаалыг мэдээлэхдээ 16 тушаалыг хугацаа хоцроож, 3 тушаалыг цахим хуудсанд байршуулаагүй Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.6, 6.4.5, 6.3.6, 6.3.7, 6.4.4, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн ба үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Байгууллагын даргад үр дүнгийн урамшуулал, 828.1 мянган төгрөгийг давхардуулж олгосон. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй.
- 1.2. Эрсдэл: Худалдан авалтуудыг цахим төлбөрийн системд мэдээлэхгүй байх, татвар төлөгч нар орлогоо нуух, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, байгууллагын удирдлага хариуцлага хүлээх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэх, худалдан авалтын төлбөрийн цахим баримтад хяналт тавьж, тулган баталгаажуулах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Аж ахуйн материалын тайланд бичиг хэрэг, хүнс, хангамжийн материалыг ангилал зөрүүтэй бүртгэсэн, бараа материалын тооллогыг чанартай, үнэн зөв хийгээгүй, бодит үлдэгдлээр байхгүй бараа материалыг байгаагаар тоолсон.

2.2. Эрсдэл: Тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалын 1 дүгээр хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1.7-д заалтуудыг хэрэгжүүлж материалыг дансны ангиллын дагуу бүртгэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ГСА-2021/13/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тусгай шилжүүлгийн санхүүжилтийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэсэн	13,843.1	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
2	Санхүүгийн тайланд НДШ-ийн болон ХХОАТ-ын өглөг үүсгэсэн барагдуулж ажиллах	1,863.4	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
3	Зардлын төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан	4,540.8	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
4	Ахмадын сангийн зарлагыг илүү бүртгэсэн	200.9	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
5	Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдлээр тайлагнасан	560.0	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
6	Бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй авсан бараа материалыг ангилал зөрүүтэй болон дутуу тайлагнасан	5,382.4	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
7	Шууд зардлыг ангилал зөрүүтэй бүртгэсэн	300.0	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
8	Дахин үнэлж бүртгэсэн хөрөнгийг тайлант үеийн орлогоор бүртгэсэн	19,623.3	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
9	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулсан тушаалыг мэдээлэхдээ 16 тушаалыг хугацаа хоцроож, 3 тушаалыг мэдээлээгүй, цахим хуудсанд байршуулаагүй	0,0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
10	Байгууллагын даргад үр дүнгийн урамшууллыг давхардуулж олгосон	828.1	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
11	Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй,	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг

Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй.				
12	Аж ахуйн материалын тайланд бичиг хэрэг, хүнс, хангамжийн материалыг ангилал зөрүүтэй бүртгэсэн, бараа материалын тооллогыг чанартай, үнэн зөв хийгээгүй, бодит үлдэгдлээр байхгүй бараа материалыг байгаагаар тоолсон.	0,0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
13	Биетээр байхгүй бараа материалыг дансны үлдэгдлээр тайлагнасан, авлага үүсгээгүй	1,368.0	Залруулга	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг Д.Оюунцэцэг
ДҮН		48,510.0			

Ажлын баримтын нэр:	Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл
Ажлын баримтын дугаар:	В501
Аудитын код:	ГСА-2021/13СТА-ТШЗ
Аудитын нэр:	Говьсүмбэр аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Төгрөгөөр	
									Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Үр дүнгийн болон мөнгөн гүйцэтгэлийн тайлан	1	Тусгай шилжүүлгийн санхүүжилтийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэсэн	13,843,100	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн	Залруулга хийгдсэн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
2	Өглөгийн данс	1	Санхүүгийн тайланд НДШ-ийн болон ХХОАТ-ын өглөг үүсгэсэн барагдуулж ажиллах	1,863,424	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн	Залруулга хийгдсэн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
3	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	1	Зардлын төлөвлөгөөг зөрүүтэй тайлагнасан	4,540,800	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн	Залруулга хийгдсэн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
4	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	1	Ахмадын сангийн зарлагыг илүү бүртгэсэн	200,850	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн	Залруулга хийгдсэн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
5	Мөнгөн хөрөнгө	1	Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдлээр тайлагнасан	560,028	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн	Залруулга хийгдсэн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
6	Бараа материал	1	Бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй авсан бараа материалыг ангилал зөрүүтэй болон дутуу тайлагнасан	5,382,400	Залруулга хийх	Зөвшөөрсөн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
7	Үр дүнгийн тайлан	1	Шууд зардлыг ангилал зөрүүтэй бүртгэсэн	300,000	Залруулга хийх	Зөвшөөрсөн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
8	Үндсэн хөрөнгө	1	Дахин үнэлж бүртгэсэн хөрөнгийг тайлант үеийн орлогоор бүртгэсэн	19,623,300	Залруулга хийх	Зөвшөөрсөн	Залруулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг

9	Хууль тогтоомжийн хэрэгжилт	1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулсан тушаалыг мэдээлэхдээ 16 тушаалыг хугацаа хоцроож, 3 тушаалыг мэдээлээгүй, цахим хуудсанд байршуулаагүй		Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
10	Цалингийн зардал	1	Байгууллагын даргад үр дүнгийн урамшууллыг давхардуулж олгосон	828,164	Төлбөрийн акт тогтоох	Зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
11	Хууль тогтоомжийн хэрэгжилт	1	Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй.	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
12	Бараа материал	1	Аж ахуйн материалын тайланд бичиг хэрэг, хүнс, хангамжийн материалыг ангилал зөрүүтэй бүртгэсэн, бараа материалын тооллогыг чанартай, үнэн зөв хийгээгүй, бодит үлдэгдлээр байхгүй бараа материалыг байгаагаар тоолсон.	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
13	Дансны авлага	1	Биетээр байхгүй бараа материалыг дансны үлдэгдлээр тайлагнасан, авлага үүсгээгүй	1,368,000	Заглуулга хийх	Зөвшөөрсөн	Заглуулсан		Дарга, нягтлан бодогч	Ц.Оюунбилэг, Д.Оюунцэцэг
				48,510,066						

Нийт дүн

Бэлтгэсэн:

Анхан шатанд хянасан:

Хоёр дахь шатанд хянасан:

Ц.Батсайхан Огноо:

Г.Наранбаяр Огноо:

Б.Сарангуяа Огноо:

2021.02.15

2021.02.15

2021.02.15

Танилцаж зөвшөөрсөн:

Ц.Оюунбилэг


Д.Оюунцэцэг

2021.02.15

Огноо:

2021.02.15

Огноо:





ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01/06

Чойр

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын даргад нэг жилийн ажлын үр дүнгээр олгох үр дүнгийн урамшуулал 828.1 мянган төгрөгийг давхардуулж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна", 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Давхардуулан олгосон үр дүнгийн урамшуулал 828,164.00 төгрөгийг барагдуулж, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого" 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ц.Оюунбилэг, нягтлан бодогч Д.Оюунцэцэг нарт хариуцуулав.

АХЛАХ АУДИТОР

АКТ ТОГТООСОН:

Ц.БАТСАЙХАН

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01/М

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроосон, хөрөнгө зарцуулсан тушаалыг мэдээлэхдээ 16 тушаалыг хугацаа хоцроож, 3 тушаалыг цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "мэдээлэл, үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, 7 дугаар зүйлийн 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан,"; 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ц.Оюунбилэг, нягтлан бодогч Д.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Ц.БАТСАЙХАН